

БИЕЭ ЗОХИСТОЙ АВЧ ЯВАХ ЗӨВЛӨМЖ

Бидний үнэ цэнэт зүйл:

ЗӨВ ХАНДЛАГА, ЗӨВ ЗАН ҮЙЛ, ЗӨВ ХУВЦАСЛАЛТ

Хандлага

1. Удирдах, удирдуулах ёс зарчмыг баримтал
2. Ажлын цагийг бүрэн, үр бүтээлтэй ашигла, ажлын цагаар ажлын байраа орхиж явахгүй байх, зайлшгүй тохиолдолд удирдлагаасаа чөлөө авах
3. Эзэмшсэн мэдлэг мэргэжлээ дээшлүүлж өөрийгөө хөгжүүл
4. Олон нийтийн хүртээл болгоогүй аливаа мэдээлэл тараахгүй байх
5. Байгууллагаас зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролц

Зан үйл

6. Ажиллаж буй орчноо хог хаягдалгүй цэвэр цэмцгэр байлгах, байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгслийг хэмнэлттэй, үр ашигтай ашигла
7. Хамт олноо болон бусдыг хүндэтгэж, өөр хоорондоо нөхөрсөг, шударга, хамтач бай
8. Хамт олны дунд элдэв хов жив, хэрүүл маргаан үүсгэх, нэр төр, албан тушаал хөөцөлдсөн үйлдэл гаргахгүй байх
9. Албан хэрэгцээний телефон утсаар хувийн асуудлыг удаан хугацаагаар ярихгүй байх
10. Ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, бүдүүлэг зан авир гаргах, өндөр чанга дуугаар маргалдах, хэрэлдэх, бусадтай зүй бусаар харьцах, хөгжим чангаар тавих

Хувцаслалт

11. Ажилтан албан үүргээ гүйцэтгэж байх үедээ цэвэр цэмцгэр, төлөв, албаны ажил хэрэгч хувцаслаж, үсний засалтанд анхаар
12. Эмэгтэй ажилтан хэт том, тод хурц өнгөтэй, гаж этгээд хэлбэр хийц бүхий бусдын анхаарал татахуйц чимэг, зүүлт зүүхгүй байх, этгээд өнгө бүхий гаж хувцас, хэт задгай энгэртэй цамц, даашинз, хэт богино банзал, платформ өсгийтэй задгай сандал өмсөхгүй байх
13. Эрэгтэй ажилтанд футболка, ноосон болон ноолууран цамцыг дангаар өмсөхгүй байх, үсээ урт ургуулахгүй байх, костюм өмсөж, зангиа зүүх
14. Ажилтан үсээ тод, хурц өнгөөр будах, содон өнгийн сор тавих, ажлын өдрүүдэд чөлөөт, спорт загвараар хувцаслахгүй байх
15. Хурц үнэртэй гоо сайхны бүтээгдэхүүн хэрэглэхгүй, ажлын байранд гоёлын болон нүдний хар шил зүүхгүй, ил харагдах элдэв шивээс тэмдэг хэрэглэхгүй байх.

ЁС ЗҮЙН ХОРОО